



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/02/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512123</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1 Албан шаардлага	8
5.2 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХАЙЛААСТ ГОЛОМТ ОНӨААТҮГ
ДАРГА С.ЛХАГВАДОРЖ ТАНАА

2024.03.15 № 228
танай _____ - ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хайлааст Голомт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дүгээр тогтоолоор байгууллагын дүрэмд, Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны А/19 тоот тогтоолоор бүтээгдэхүүний үнэ тарифт тус тус өөрчлөлт оруулсан байна.

Аудитын гол асуудал

Хайлааст Голомт ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаар Сумын ИТХ-ын 2023 оны А/03 тогтоолоор 1,759,245.1 мянган төгрөгийн цэвэр, бохир усны шугам, барилга байгууламж шинээр ашиглалтад орж, үйл ажиллагааг эхлүүлсэн боловч төлбөрт үйлчилгээний төлбөрийн үнэ тарифыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгоогүйгээс орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хайлааст Голомт ОНӨААТҮГ газар нь 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулжээ. Сүхбаатар сумын Засаг даргатай гэрээ байгуулж, гүйцэтгэлийг үнэлээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,815,779.07	64,686,898.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,062,265.75	8,860,850.34
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,062,265.75	8,860,850.34
31210	Төгрөг	14,062,265.75	8,860,850.34
31213	Арилжааны банк дахь харилцах	14,062,265.75	8,860,850.34
33	АВЛАГА	43,401,815.92	44,134,704.62
33401	Дансны авлага /ТӨҮГ/	25,306,865.38	25,994,299.07
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	3,555,987.99	3,601,443.00
33500	Бусад авлага	14,538,962.55	14,538,962.55
33510	Байгууллагаас авах авлага	4,986,781.46	4,986,781.46
33520	Хувь хүмүүсээс авах авлага	9,552,181.09	9,552,181.09
34	УРЬДЧИЛГАА	84,259.02	84,259.02
34600	Урьдчилж гарсан зардал	84,259.02	84,259.02
35	БАРАА МАТЕРИАЛ	21,267,438.38	11,607,084.86
35400	Хангамжийн материал	21,267,438.38	11,607,084.86
35420	Аж ахуйн материал	6,179,372.91	1,573,250.27
35430	Сэлбэг хэрэгсэл	1,424,013.64	1,359,468.55
35440	Түлш, шатах тослох материал	13,664,051.83	8,674,366.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,213,586,102.16	3,148,285,838.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,213,586,102.16	3,148,285,838.62
39200	Биет хөрөнгө	3,192,406,902.16	3,127,106,638.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,955,628,979.28	2,821,325,578.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-171,848,545.66	-203,424,837.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,000,000.00	193,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-39,562,499.96	-60,062,499.96
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	529,874,377.81	642,261,765.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-335,358,853.20	-325,265,443.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,423,566.82	67,423,566.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,231,219.60	-10,632,587.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,712,316.27	11,712,316.27
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,231,219.60	-9,231,219.60
39300	Биет бус хөрөнгө	21,179,200.00	21,179,200.00
39301	Програм хангамж	21,679,200.00	21,679,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,292,401,881.23	3,212,972,737.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,846,238,330.18	2,792,803,060.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,846,238,330.18	2,792,803,060.35
41300	Өглөг	47,131,473.08	30,592,623.77
41360	Бусад өглөг	47,131,473.08	30,592,623.77
41361	Байгууллагад төлөх өглөг	35,616,498.77	30,592,623.77
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,054,515.61	0
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	9,460,458.70	0
41400	Урьдчилж орсон орлого	2,799,106,857.10	2,762,210,436.58
41440	Бусад урьдчилж орсон орлого	2,799,106,857.10	2,762,210,436.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	446,163,551.05	420,169,677.11
51	Засгийн газрын хувь оролцоо	446,163,551.05	420,169,677.11
51100	Засгийн газрын оруулсан капитал	559,377,218.00	559,377,218.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	559,377,218.00	559,377,218.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-163,559,978.95	-189,553,852.89

51210	Өмнөх үеийн үр дүн	-99,961,965.22	-163,559,978.95
51220	Тайлант үеийн үр дүн	-63,598,013.73	-25,993,873.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,346,312.00	50,346,312.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,292,401,881.23	3,212,972,737.46

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	151,522,460.11	166,020,373.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	151,522,460.11	166,020,373.93
120	Нийтлэг татварын бус орлого	151,522,460.11	166,020,373.93
120009	Бусад орлого	288,655,602.20	162,765,406.24
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	266,276,720.00	431,887,117.31
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	409,145,497.13	428,647,516.35
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	5,735,635.04	15,366.73
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	215,120,473.84	192,014,247.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,120,473.84	192,014,247.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,120,473.84	192,014,247.87
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,120,473.84	192,014,247.87
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	212,599,114.52	192,011,328.19
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	1,947,795.82	1,383.01
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	573,563.50	1,536.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-63,598,013.73	-25,993,873.94
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-63,598,013.73	-25,993,873.94

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-92,994,026.97	516,729,503.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-6,967,938.25	-6,967,938.25
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-99,961,965.22	509,761,564.78
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-63,598,013.73	-63,598,013.73
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-163,559,978.95	446,163,551.05
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-163,559,978.95	446,163,551.05
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-163,559,978.95	446,163,551.05
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-25,993,873.94	-25,993,873.94
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-189,553,852.89	420,169,677.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	367,925,476.22	477,116,681.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	367,925,476.22	477,116,681.83

120	Нийтлэг татварын бус орлого	367,925,476.22	477,116,681.83
120009	Бусад орлого	78,317,511.60	9,725,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	289,607,964.62	467,391,681.83
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	427,943,739.27	479,031,927.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,943,739.27	479,031,927.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,943,739.27	479,031,927.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,722,991.35	156,242,514.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	147,722,991.35	156,242,514.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,290,053.73	57,124,807.12
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	51,290,053.73	57,124,807.12
2104	Хангамж, бараа материалын зардал	123,299,006.00	127,171,188.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	18,486,910.00	15,541,992.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	104,812,096.00	111,629,196.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,631,688.19	138,493,418.23
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	1,947,795.82	0
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	28,914,567.62	65,590,031.76
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	47,096,285.23	52,532,150.46
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	27,673,039.52	20,371,236.01
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-60,018,263.05	-1,915,245.52
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	5,162,071.54	13,830.11
140007	Хүлээн авсан хүүний орлого	5,162,071.54	13,830.11
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,029,000.00	3,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,029,000.00	3,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,029,000.00	3,300,000.00
225104	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	3,029,000.00	3,300,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	2,133,071.54	-3,286,169.89
14	Бусад эх үүсвэр	44,000,000.00	0
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	44,000,000.00	0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	44,000,000.00	0
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	44,000,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-57,885,191.51	-5,201,415.41
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	71,947,457.26	14,062,265.75
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,062,265.75	8,860,850.34

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023оны Гүйцэтгэл	2024 оны төлөвлөгөө	2024 оны Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	гкал	3.92	3.95	3.95
2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн тоо		81.00	81.00	81.00
	-айл өрхийн тоо	ш	57.00	57.00	57.00
	-Албан байгууллагын тоо	ш	24.00	24.00	24.00
3	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн үнэ	төг	1,568.00	1,623.00	1,623.00
4	Нийт орлого	мян.төг	367,925.40	520,000.00	594,667.90

	цэвэр борлуулалт	мян.төг	367,925.40	480,000.00	431,887.10
5	Нийт зардал	мян.төг	427,943.70	519,263.70	620,661.70
	Үүнээс: удирдлагын зардал	мян.төг	100,773.80	192,011.30	192,011.30
6	Татварын өмнөх ашиг	мян.төг	(60,018.20)	936.30	(25,993.80)
7	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	(60,018.20)	936.30	(25,992.30)
8	Төсвийн төлбөр		2,420.00	2,420.00	2,420.00
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	0.86	0.99	1.00
10	Нийт авлага	мян.төг	43,401.60	43,401.60	44,089.00
11	Нийт өглөг	мян.төг	37,671.00	37,671.00	30,592.60
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	37,671.00	37,671.00	30,592.60
12	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ	мян.төг	1,754,600.00	137,000.00	137,000.00
13	Ажиллагсадын тоо	мян.төг	25.00	25.00	15.00
14	Цалингийн сан	мян.төг	147,722.90	156,242.50	156,242.50
15	Нийт хөрөнгийн дүн	мян.төг	3,292,401.80	3,212,972.70	3,212,972.70
16	-эргэлтийн хөрөнгө	мян.төг	78,815.70	64,686.80	64,686.80
	үүнээс бараа материал	мян.төг	21,267.40	11,607.00	11,607.00
17	-үндсэн хөрөнгө	мян.төг	3,192,406.90	3,127,106.60	3,127,106.60

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар олон жилийн насжилттай авлагыг барагдуулж ажиллах 1 албан шаардлага, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

5.1.1 Олон жилийн насжилттай авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5/дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/ заалттай нийцэхгүй байна.

5.1.2 Өмнөх оны аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 /Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно/, 42.3 / Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ/ дахь заалтыг үндэслэн хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага барагдуулагүй	1	0			1	0						
АШ хэрэгжүүлээгүй									1	0		
Дүн	2	0			1	0			1	0		